ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

## *MONTHLY BULLETIN OF STATISTICS*

**2017/6**



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn

# ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл ..........................................................................................
Аргачлалын тайлбар..........................................................................................
I. Нийгмийн байдал..........................................................................................
II. Нийгмийн даатгал, халамж…..........................................................................
III. Эрүүл мэнд ..........................................................................................
IV. Гэмт хэрэг ..........................................................................................
V. Үнэ..........................................................................................
VI. Төсөв..........................................................................................
VII. Хөдөө аж ахуй ..........................................................................................
VIII. Аж үйлдвэр ..........................................................................................
IX. Цаг уур..........................................................................................
Хавсралт..........................................................................................

## Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэл:

Сумдын нэр:

СҮ Сүмбэр

БТ Баянтал

ШГ Шивээговь

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XII зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй

0.0 Маш бага тоо+, - Зөрүү

- Гүйцэтгэл байхгүй* Дахин

"Үнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:**

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

- **Нийгмийн даатгал, халамж:**

✓ Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

✓ Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

- **Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөнд тооцно.

✓ **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

✓ **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

- **Гэмт хэрэг:**

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

✓ Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.

✓ Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

✓ Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.

✓ Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.

✓ Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.

- **Үнэ**

Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ нь хэрэглэгчийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны эхний 2 сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

- **Төсөв санхүү:**

Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

- **Хөдөө аж ахуй:**

Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын Тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.

✓ Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

✓ Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул, хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

- **Аж үйлдвэр:**

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

**Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал**

## I.Нийгмийн байдал

### I.1 Ажил хайгч иргэд

Тайлант сарын эцэст Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэд 457, үүнээс ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 298 байгаагийн 165 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 134 буюу 81.7 хувиар өсч, өмнөх сараас 27 буюу 8.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зургаадугаар сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 31 ажлын байрны захиалга иржээ.

Тайлант сард 17 иргэн ажилд зуучлагдсаны 11 буюу 64.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажилд зуучлуулсан иргэд өмнөх оны мөн үед байгаагүй болно.

Зураг I.1.Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, жил бүрийн тайлант сарын эцэст




Ажил хайгч ажилгүй иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 72, 25-34 насны 101, 35-44 насны 67, 45-54 насны 49, 55 түүнээс дээш насны 9 иргэн байна.

### I.2 Ердийн хөдөлгөөн

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2017 оны эхний 6 сарын байдлаар 161 эх амаржиж, 165 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 60 буюу 27.1 хувиар, төрсөн хүүхдийн тоо 58 буюу 26.0 хувиар тус тус буурсан байна.

Нас баралт 52, бүртгүүлсэн гэр бүл 33, цуцалсан гэр бүл 14 байгаа нь өмнөх оны мөн үеэс цуцалсан гэр бүл 4 буюу 40.0 хувиар өсч, нас баралт 3 буюу 5.5 хувиар, бүртгүүлсэн гэр бүл 7 буюу 17.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 2 хүүхэд үрчлэгдсэн. Шилжилт

хөдөлгөөний мэдээгээр 230 хүн шилжин ирж, 215 хүн шилжин явсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал шилжин ирэлт 45.8 хувиар, шилжин явалт 25.3 хувиар тус тус буурчээ.

Зураг I.2.Төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 6 сарын байдлаар




## II. Нийгмийн даатгал, халамж

### II.1 Нийгмийн даатгал

2017 оны эхний 6 сарын байдлаар Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлого 4187.8 сая төгрөг, зарлага 4022.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс орлого 524.3 сая төгрөгөөр буюу 14.3 хувиар өсч, зарлага 782.9 сая төгрөгөөр буюу 16.3 хувиар буурлаа.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт 108.6 хувьтай, зарлагын гүйцэтгэл 74.7 хувьтай байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Монгол даатгал, Ард даатгал компаниудын салбарууд 2017 оны эхний хагас жилд 134. 6 сая төгрөгийн орлого олж, 19.1 сая төгрөгийн нөхөн төлбөр хийсэн байна. Нөхөн төлбөрийн 39.6 хувийг хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгалд, 34.1 хувийг жолоочийн хариуцлагын даатгалд тус тус зориулсан байна.

### II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2017 оны эхний 6 сарын байдлаар 3568 хүнд 763.5 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамж хүртэгсэд 290 хүн буюу 7.5 хувиар буурч, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 75.9 сая төгрөг буюу 11.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

- ✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2017 оны эхний 6 сарын байдлаар 922 хүн хамруулж 369.4 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 258 хүн буюу 21.9 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 21.0 сая төгрөг буюу 5.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- ✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2017 оны эхний 6 сарын байдлаар 2646 хүн хамруулж 394.1 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 32 хүн буюу 1.2 хувиар буурч, олгосон халамж үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж 96.9 сая төгрөг буюу 32.6 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

## II.3 Дундаж цалин

Аймгийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн 2017 оны 6 дугаар сарын мэдээгээр 190 байгууллагын 5077 даатгуулагч иргэн, үүнээс 631 нь сайн дурын даатгуулагч байна. Ажиллагсдын дундаж цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 11 аж ахуйн нэгж, байгууллагын 357 ажилтны дундаж цалин 747.8 мянган төгрөг, төсөвт 55 байгууллагын 1614 ажилтны дундаж цалин 658.2 мянган төгрөг, 2 Хувьцаат Компаний 643 ажилтны дундаж цалин 1184.2 мянган төгрөг, 105 ХХКомпаний 1678 ажилтны дундаж цалин 757.5 мянган төгрөг, бусад 17 аж ахуйн нэгж байгууллагын 154 ажилтны дундаж цалин 356.8 мянган төгрөг боллоо.

Зураг II.1.Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2017 оны эхний 6 сарын байдлаар




## III.Эрүүл мэнд

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2017 оны эхний 6 сарын байдлаар 199 эх амаржиж, 2016 оны мөн үетэй харьцуулахад 29 буюу 12.7 хувиар буурсан байна. Амьд төрсөн хүүхэд 199 үүнээс 105 нь хүү, 94 нь охин байна. Өмнөх оны мөн үеэс амьд төрсөн хүүхэд 30 буюу 13.1 хувиар буурсан байна.

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 3 бүртгэгдсэн байна. Эхийн эндэгдэл бүртгэгдээгүй.

Зураг III.1. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 6 сарын байдлаар



Халдварт өвчин эхний 6 сарын байдлаар 105 буюу 10000 хүн амд 63.0 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 92 тохиолдлоор буурчээ.

Зураг III.2.Нас баралт, жил бүрийн эхний 6 сарын байдлаар




Он гарсаар давхардсан тоогоор 56715 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 12253 буюу 17.8 хувиар, 2528 өвчтөн эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 131 буюу 4.9 хувиар буурсан байна.

2017 оны эхний 6 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 3339, халдварт өвчин 105 бүртгэгдсэн байна.

Зураг III.3.Амьгүй төрсөн хүүхэд болон нялхасын эндэгдэл, жил бүрийн эхний 6 сарын байдлаар



## IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2017 оны эхний 6 сарын байдлаар 90 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 24 буюу 21.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг IV.1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 6 сарын байдлаар




Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэргийн тоо буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болон хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг тодорхой хэмжээгээр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэрэг 9 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2 дахин буурсан. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 75.0 болсон нь өмнөх оны мөн үеэс 5 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 66 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар өссөн байна.

Зураг IV.2.Гэмт хэргийн ангилал, жил бүрийн эхний 6 сарын байдлаар




Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2017 оны эхний 6 сарын байдлаар 197.0 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 149.0 сая төг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирлын хэмжээ 51.0 сая төгрөгөөр буюу 20.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 29.0 сая төгрөг буюу 16.3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2017 оны эхний 6 сарын байдлаар давхардсан тоогоор 356 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 105 хүнээр буюу 22.8 хувиар буурсан байна.

Зураг IV.3.Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо жил бүрийн эхний 6 сарын байдлаар




## V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2017 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар, 2016 оны жилийн эцсээс 3.5 хувиар өсч, өмнөх сараас 0.2 хувиар буурсан байна.

Хүснэгт V.1.Хэрэглээний үнийн индекс, 2017 оны 6 дугаар сард, бүлгийн дүнгээр

| Бараа үйлчилгээний бүлэг | $\frac{2017.VI}{2016.VI}$ | $\frac{2017.VI}{2016.XII}$ | $\frac{2017.VI}{2017.V}$ |
|---|---|---|---|
| Ерөнхий индекс | 103.2 | 103.5 | 99.8 |
| Хүнсний бараа, ундаа, ус | 106.4 | 107.6 | 98.9 |
| Согтууруулах ундаа, тамхи | 104.0 | 103.6 | 103.4 |
| Хувцас, бөс бараа, гутал | 108.5 | 101.8 | 100.0 |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш | 104.8 | 98.9 | 99.4 |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 99.5 | 100.3 | 100.0 |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ | 102.4 | 100.8 | 100.0 |
| Тээвэр | 110.1 | 109.4 | 100.0 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 99.2 | 100.0 | 100.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 101.9 | 100.0 | 100.0 |
| Боловсролын үйлчилгээ | 100.0 | 100.0 | 100.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр | 100.2 | 100.0 | 100.0 |
| Бусад бараа, үйлчилгээ | 102.1 | 101.1 | 100.0 |

Эх үүсвэр:Үндэсний статистикийн хорооны сарын мэдээ

## VI. Төсөв санхүү, банк

2017 оны эхний 6 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 7399.4 сая төгрөг, гүйцэтгэлээр 7585.0 сая төгрөг болж 102.5 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 10 378.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 7095.1 сая төгрөг болж 68.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

2017 оны эхний 6 сарын байдлаар авлагын үлдэгдэл 15.6 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 99.3 сая төгрөг байна.

Зураг VI.1.Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр




Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй банкуудын салбарын эхний хагас жилийн зарим үзүүлэлтийг танилцуулбал цахим банкны үйлчилгээний хэрэглэгчид давхардсан тоогоор 32.4 мянгад хүрч, зээлийн бүтээгдэхүүн дунджаар 15, зээлийн дундаж хүү сарын 1.5 хувь болсон байна. Давхардсан тоогоор 28 аж ахуйн нэгж байгууллагад 1.6 тэрбум төгрөгийн, 7517 иргэнд 46.1 тэрбум төгрөгийн, үүнээс 476 малчинд 2.2 тэрбум төгрөгийн зээл олгосон үзүүлэлттэй байна.

## VII. Мал аж ахуй, газар тариалан

Аймгийн хэмжээнд 2016 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 185558 хээлтэгч малын 140828 буюу 75.9 хувь нь төллөсөн байна. Төл бойжилт 99.0 хувьтай байна. 2017 оны эхний 6 сарын байдлаар 2165 толгой том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 5.3 дахин бага байна. Том малын зүй бус хорогдлын 19.8 хувь нь хээлтэгч мал байна.

Зураг VII.1.Төллөсөн хээлтэгч, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, толгойгоор



Зураг VII.2.Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, толгойгоор




2017 оны 6 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 38.7 га талбайд төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалсан байна. Тариалсан талбайн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал төмс 5.7 га талбайгаар буюу 24.9 хувиар, хүнсний ногоо 1.0 га талбайгаар буюу 5.4 хувиар, тэжээлийн ургамал 5.9 га талбайгаар буюу 2.4 дахин буурсан байна.

Зураг VII.3.Тариалсан талбай, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар, га






## VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2017 оны эхний 6 сарын байдлаар 21.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум төгрөг буюу 6.8 хувиар, оны үнээр 23.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.9 тэрбум төгрөг буюу 14.7 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нийт бүтээгдэхүүний 90.4 хувь буюу 19.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 91.6 хувь буюу 21.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Зураг VIII.1.Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр




## IX. Цаг агаарын мэдээ 6 дугаар сарын байдлаар

Хур тунадас: Энэ сард нийт 4.3 мм хур тунадас орсон байна.

Салхи: Ихэнх хугацаанд 5 -10 м/сек, хамгийн их хурд нь 12 м/сек хүрч салхилсан.

Агаарын температур: Дунджаар 21.0 хэм дулаан, хамгийн ихдээ 35.5 хэм  дулаан байлаа.

### 2017 оны 7 дугаар  сарын ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Уур амьсгалын дунджаар агаарын температурын  сарын дундаж  22-27 хэм  дулаан байх бөгөөд олон жилийн дунджаас 1.0-1.5 хэмээр дулаан байх төлөвтэй.

Говьсүмбэр аймгийн нутгаар энэ сард орох хур тунадас нь олон жилийн дунджийн орчим байна. Нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар, хоёр ба гуравдугаар арав хоногийн эхэн болон дунд үеэр зарим газраар, нэг болон хоёрдугаар арав хоногийн эхээр нутгийн хойд хэсгээр түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Салхи борооны өмнө зарим газраар түр зуур шируүснэ.



1 дүгээр зураг. 2 дугаар сарын агаарын температурын уур амьсгалын дундаж(°C)



3 дугаар зураг. 2 дугаар сард ордог хур тунадасны уур амьсгалын дундаж (мм)

**ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 6 сарын байдлаар**

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ \mathrm{I-VI}}{2016\ \mathrm{I-VI}}\%$ |
|---|---|---|---|---|
| Нийгмийн статистик | | | | |
| Амьд төрсөн хүүхэд | хүүхэд | 229 | 199 | 86.9 |
| Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст | хүн | 164 | 298 | 181.7 |
| Халдварт өвчнөөр өвчлөгсөд | хүн | 197 | 105 | 53.3 |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг | хүн | 114 | 90 | 78.9 |
| Эдийн засгийн статистик | | | | |
| Орон нутгийн төсвийн орлого | сая.төг | 7997.6 | 7585.0 | 94.8 |
| Орон нутгийн төсвийн зарлага | сая.төг | 7018.2 | 7095.1 | 101.1 |
| Авлага | сая.төг | 19.3 | 15.6 | 80.8 |
| Өглөг | сая.төг | 553.2 | 99.3 | 18.0 |
| Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт | сая.төг | 20526.8 | 21912.5 | 106.8 |
| Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт | сая.төг | 20192.7 | 23168.2 | 114.7 |
| Төллөсөн хээлтэгч | толгой | 150598 | 140828 | 93.5 |
| Гарсан төл | толгой | 151784 | 141641 | 93.3 |
| Хорогдсон төл | толгой | 3335 | 1370 | 41.0 |
| Бойжсон төл | толгой | 148449 | 140271 | 94.5 |
| Том малын зүй бусын хорогдол | толгой | 11399 | 2165 | 19.0 |

## I.1 АЖЛЫН БАЙРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 6 сарын байдлаар

| Үзүүлэлтүүд | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ \mathrm{I-VI}}{2016\ \mathrm{I-VI}}\%$ |
|---|---|---|---|
| Ажил хайгч иргэд, сарын эцэст | 258 | 457 | 177.1 |
| Үүнээс: эмэгтэй | 143 | 264 | 184.6 |
| Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст | 164 | 298 | 181.7 |
| Үүнээс: эмэгтэй | 91 | 165 | 181.3 |
| Ажлын байрны захиалга | 0 | 31 | * |
| Ажилд зуучлагдсан иргэд | 0 | 17 | * |
| Үүнээс: эмэгтэй | 0 | 11 | * |

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

## I.2 ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

| Үзүүлэлтүүд | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ \mathrm{I-VI}}{2016\ \mathrm{I-VI}}\%$ |
|---|---|---|---|
| Амаржсан эх | 221 | 161 | 72.9 |
| Төрсөн хүүхэд | 223 | 165 | 74.0 |
| Үрчлэгдсэн хүүхэд | 3 | 2 | 66.7 |
| Бүртгүүлсэн гэр бүл | 40 | 33 | 82.5 |
| Цуцалсан гэр бүл | 10 | 14 | 140.0 |
| Нас баралт | 55 | 52 | 94.5 |
| Шилжин ирсэн | 424 | 230 | 54.2 |
| Шилжин явсан | 288 | 215 | 74.7 |

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

## II.1 ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

| Сангийн төрөл | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ \mathrm{I-VI}}{2016\ \mathrm{I-VI}}\%$ |
|---|---|---|---|
| ЭМНД-ын сангийн орлого, сая.төг | 3663.5 | 4187.8 | 114.3 |
| ЭМНД-ын сангийн зарлага, сая.төг | 4805.1 | 4022.2 | 83.7 |

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн мэдээ

II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

| Үзүүлэлт | 2016 I-VI | | 2017 I-VI | | $\frac{2017\ \mathrm{I-VI}}{2016\ \mathrm{I-VI}}\%$ | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хүн | Мөнгөн дүн | Хүн | Мөнгөн дүн | Хүн | Мөнгөн дүн |
| Нийгмийн халамжийн сангийн дүн | 3858 | 687.6 | 3568 | 763.5 | 92.5 | 111.0 |
| Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 1180 | 390.4 | 922 | 369.4 | 78.1 | 94.6 |
| Халамжийн тэтгэвэр | 267 | 186.4 | 260 | 194.2 | 97.4 | 104.2 |
| Нөхцөлт мөнгөн тэтгэмж | 913 | 204.0 | 662 | 175.2 | 72.5 | 88.9 |
| Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж | 2678 | 297.2 | 2646 | 394.1 | 98.8 | 132.6 |
| Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | 688 | 44.3 | 712 | 129.2 | 103.5 | 291.6 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | 148 | 34.8 | 91 | 15.5 | 61.5 | 44.5 |
| Нийгмийн халамжийн үйлчилгээ | 430 | 22.0 | 379 | 17.4 | 88.1 | 79.1 |
| Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж | 242 | 30.9 | 250 | 64.4 | 103.3 | 208.4 |
| Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | 7 | 6.2 | 5 | 5.1 | 71.4 | 82.3 |
| Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж | 1163 | 159.0 | 1209 | 162.6 | 104.0 | 102.3 |

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

| Үзүүлэлт | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ I-VI}{2016\ I-VI}\%$ |
|---|---|---|---|
| Төрсөн эх | 228 | 199 | 87.3 |
| Амьд төрсөн хүүхэд | 229 | 199 | 86.9 |
| Эрэгтэй | 105 | 105 | 100.0 |
| Эмэгтэй | 124 | 94 | 75.8 |
| Амьгүй төрсөн хүүхэд | 2 | 1 | 50.0 |
| Нийт нас баралт | 40 | 42 | 105.0 |
| Эмнэлгийн нас баралт | 10 | 3 | 30.0 |
| Хоног болоогүй нас баралт | 6 | 4 | 66.7 |
| 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл | 6 | 1 | 16.7 |
| 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл | 2 | 3 | 150.0 |
| Эмчлэгдсэн өвчтөн | 2659 | 2528 | 95.1 |
| Амбулаторийн үзлэг | 68968 | 56715 | 82.2 |
| Халдварт өвчин | 197 | 105 | 53.3 |

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээ

IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , жил бүрийн эхний 6 сарын байдлаар, төрлөөр

| Үзүүлэлт | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ I-VI}{2016\ I-VI}\%$ |
|---|---|---|---|
| Бүртгэгдсэн гэмт хэрэг | 114 | 90 | 78.9 |
| Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг | 53 | 42 | 79.2 |
| Өмчлөх эрхийн эсрэг | 40 | 30 | 75.0 |
| Нийгмийн аюулгүй байдлын эсрэг | 5 | 3 | 60.0 |
| Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 5 | 10 | 200.0 |
| Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг | 4 | 3 | 75.0 |
| Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг | 2 | 1 | 50.0 |
| Бусад гэмт хэрэг | 5 | 1 | 20.0 |

| | | | |
|---|---|---|---|
| Гэмт хэрэгт холбогдогсод | 108 | 110 | 101.9 |
| 15 хүртэлх насны | 1 | 2 | 200.0 |
| 16-34 насны | 81 | 67 | 82.7 |
| 35 ба түүнээс дээш насны | 26 | 41 | 157.7 |
| Боловсрол – Дээд | 17 | 19 | 111.8 |
| Боловсрол - Тусгай дунд | 13 | 6 | 46.2 |
| Боловсрол – Бүрэн дунд | 42 | 34 | 81.0 |
| Боловсрол – Бүрэн бус дунд | 21 | 28 | 133.3 |
| Боловсрол – Бага | 11 | 6 | 54.5 |
| Боловсролгүй | 4 | 17 | 425.0 |
| Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн | 4 | 9 | 225.0 |
| Ажилгүй иргэд үйлдсэн | 57 | 48 | 84.2 |
| Эмэгтэй хүн оролцсон | 19 | 15 | 78.9 |
| Хүүхэд оролцсон | 6 | 9 | 150.0 |
| Бүлгээр үйлдсэн | 14 | 7 | 50.0 |
| Согтуугаар үйлдсэн | 36 | 34 | 94.4 |
| Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал | 114 | 90 | 78.9 |
| Гудамж талбайд | 34 | 24 | 70.6 |
| Гэмт хэргийн улмаас нас барсан | 4 | 3 | 75.0 |
| Гэмт хэргийн улмаас гэмтсэн | 64 | 66 | 103.1 |
| Учирсан хохирол / сая.төг / | 248.0 | 197.0 | 79.4 |
| Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг / | 178.0 | 149.0 | 83.7 |

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтсийн мэдээ

VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

| Үзүүлэлт | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ \mathrm{I-VI}}{2016\ \mathrm{I-VI}}\%$ |
|---|---|---|---|
| Нийт орлого | 7997.6 | 7585.0 | 94.8 |
| Урсгал орлого | 2714.5 | 3009.9 | 110.9 |
| Татварын орлого | 2501.4 | 2237.5 | 89.4 |
| Татварын бус орлого | 213.1 | 772.4 | 362.5 |
| Тусламжийн орлого | 5283.1 | 4575.1 | 86.6 |

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

| Үзүүлэлт | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ I-VI}{2016\ I-VI}\%$ |
|---|---|---|---|
| Нийт зарлага | 7018.2 | 7095.1 | 101.1 |
| Урсгал зардал | 6218.6 | 6968.8 | 112.1 |
| Хөрөнгийн зардал | 799.6 | 126.3 | 15.8 |

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

| Үзүүлэлт | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ I-VI}{2016\ I-VI}\%$ |
|---|---|---|---|
| Авлага | 19.3 | 15.6 | 80.8 |
| Өглөг | 553.2 | 99.3 | 18.0 |
| Төсөвт байгууллагын тоо | 51 | 49 | 96.1 |
| Төсөвт байгууллагын ажиллагсад | 769 | 783 | 101.8 |

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

| Төрөл | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ I-VI}{2016\ I-VI}\%$ |
|---|---|---|---|
| Бүгд | 150598 | 140828 | 93.5 |
| Ингэ | 190 | 120 | 63.2 |
| Гүү | 3830 | 3974 | 103.8 |
| Үнээ | 3861 | 3666 | 94.9 |
| Эм хонь | 73019 | 69113 | 94.7 |
| Эм ямаа | 69698 | 63955 | 91.8 |

VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

| Сумд | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ I-VI}{2016\ I-VI}\%$ |
|---|---|---|---|
| Дүн | 150598 | 140828 | 93.5 |
| Баянтал | 23927 | 21590 | 90.2 |
| Сүмбэр | 111712 | 102074 | 91.4 |
| Шивээговь | 14959 | 17164 | 114.7 |

VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

| Төрөл | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ I-VI}{2016\ I-VI}\%$ |
|---|---|---|---|
| Бүгд | 148449 | 140271 | 94.5 |
| Ботго | 178 | 116 | 65.2 |
| Унага | 3779 | 3957 | 104.7 |
| Тугал | 3719 | 3638 | 97.8 |
| Хурга | 72249 | 68838 | 95.3 |
| Ишиг | 68524 | 63722 | 93.0 |

VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

| Сумд | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ I-VI}{2016\ I-VI}\%$ |
|---|---|---|---|
| Дүн | 148449 | 140271 | 94.5 |
| Баянтал | 23780 | 21720 | 91.3 |
| Сүмбэр | 109979 | 101333 | 92.1 |
| Шивээговь | 14690 | 17218 | 117.2 |

VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

| Төрөл | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ I-VI}{2016\ I-VI}\%$ |
|---|---|---|---|
| Бүгд | 11399 | 2165 | 19.0 |
| Тэмээ | 1 | 3 | 300.0 |
| Адуу | 304 | 29 | 9.5 |
| Үхэр | 453 | 105 | 23.2 |
| Хонь | 4040 | 803 | 19.9 |
| Ямаа | 6601 | 1225 | 18.6 |

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

| Сумд | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ I-VI}{2016\ I-VI}\%$ |
|---|---|---|---|
| Дүн | 11399 | 2165 | 19.0 |
| Баянтал | 1981 | 255 | 12.9 |
| Сүмбэр | 6470 | 1827 | 28.2 |
| Шивээговь | 2948 | 83 | 2.8 |

VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

| Төрөл | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ I-VI}{2016\ I-VI}\%$ |
|---|---|---|---|
| Бүгд | 3597 | 429 | 11.9 |
| Тэмээ | 0 | 0 | * |
| Адуу | 213 | 7 | 3.3 |
| Үхэр | 152 | 27 | 17.8 |
| Хонь | 1381 | 208 | 15.1 |
| Ямаа | 1851 | 187 | 10.1 |

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

| Сумд | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ I-VI}{2016\ I-VI}\%$ |
|---|---|---|---|
| Дүн | 3597 | 429 | 11.9 |
| Баянтал | 158 | 31 | 19.6 |
| Сүмбэр | 680 | 377 | 55.4 |
| Шивээговь | 2759 | 21 | 0.8 |

VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

| Үзүүлэлт | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ I-VI}{2016\ I-VI}\%$ |
|---|---|---|---|
| Нийт | 20596.0 | 21912.5 | 106.4 |
| Нүүрс | 19 463.2 | 19 830.4 | 101.9 |
| Дулаан | 934.9 | 985.9 | 105.5 |
| Цэвэр ус | 93.8 | 158.7 | 169.2 |
| Сувагжуулалт | 34.9 | 63.3 | 181.4 |
| Бусад | 69.2 | 874.2 | 1263.3 |

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

| Үзүүлэлт | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ I-VI}{2016\ I-VI}\%$ |
|---|---|---|---|
| Нийт | 20 270.9 | 23 168.2 | 114.3 |
| Нүүрс | 19 129.1 | 21 252.2 | 111.1 |
| Дулаан | 1039.8 | 1158.9 | 111.5 |
| Усан хангамж, ус ариутгал | 3.2 | 3.3 | 103.1 |
| Бусад | 98.8 | 753.8 | 762.9 |

VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 6 сарын байдлаар

| Үзүүлэлт | 2016 I-VI | 2017 I-VI | $\frac{2017\ \mathrm{I-VI}}{2016\ \mathrm{I-VI}}\%$ |
|---|---|---|---|
| Нүүрс борлуулалт /үнийн дүнгээр, сая.төг/ | 19 129.1 | 21 252.2 | 111.1 |
| Нүүрс гаргалт /үнийн дүнгээр, сая.төг/ | 19 463.2 | 19 830.4 | 101.9 |
| Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/ | 846.1 | 877.6 | 103.7 |
| Ажиллагсад | 595 | 553 | 92.9 |

Е-майл хаяг: govisumber@nso.mn
Вэб хаяг: govisumber.nso.mn
Мэдээллийн сангийн хаяг: www.1212.mn
Утас: 70543222, 70543017